

## ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

#### Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2025/091/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Мөрөн сум

2025 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Аудитор: Б. Ариунтуяа 99036832

Утас: Цахим хаяг: [ariuntuyab@audit.gov.mn](mailto:ariuntuyab@audit.gov.mn)

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас: 99389208 Цахим хаяг: [b\\_myadagmaaa@yahoo.com](mailto:b_myadagmaaa@yahoo.com)

Аудитор Г.Сувд

Утас: 88115129 Цахим хаяг: [g.suvd2018@gmail.com](mailto:g.suvd2018@gmail.com)

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 1/166  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦАГААН УУЛ  
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГА Н.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Цагаан Уул сумын эрүүл мэндийн төв нь 2024 онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,494,729.2 мянган төгрөгийн санхүүжилтийг авахаас 1,241,703.3 мянган төгрөгийг санхүүжилтийг авч 253,025.9 мянган төгрөгийн авлагатай гарсан байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 186,335.9 мянган төгрөгийн 10 алдаа, зөрчлийг илрүүлснээс 181,404.3 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 5 зөрчилд зөвлөмж, 2 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

#### Бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас сумын эрүүл мэндийн төвтэй байгуулсан анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах 2024 оны гэрээний биелэлтийг 81.6 хувьтай дүгнэсэн байна.

672502203

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>239,001,918.30</b>	<b>456,409,109.46</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	40,191,057.85	2,820,023.98
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	40,191,057.85	2,820,023.98
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	40,191,057.85	2,820,023.98
31211	Төрийн сангийн харилцах	40,191,057.85	2,820,023.98
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	40,416,549.70	253,025,904.52
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	40,416,549.70	253,025,904.52
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	158,394,310.75	200,563,180.96
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	56,729,154.91	77,493,620.03
35130	Эм боох материал	56,729,154.91	77,493,620.03
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	101,665,155.84	123,069,560.93
35410	Бичиг хэргийн материал	14,097,700.00	6,502,300.00
35420	Аж ахуйн материал	59,738,045.94	82,993,991.41
35430	Сэлбэг хэрэгсэл	3,115,000.00	3,115,000.00
35440	Түлш, шатах тослох материал	911,400.00	4,891,880.00
35450	Барилгын засварын материал	12,652,750.00	19,267,750.00
35460	Хүнсний материал	11,150,259.90	6,298,639.52
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>660,854,998.41</b>	<b>754,434,302.42</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	660,854,998.41	754,434,302.42
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	647,194,998.33	740,818,302.32
39201	Барилга, байгууламж, орон сууц	330,915,290.00	330,915,290.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-131,179,470.40	-143,945,834.44
39203	Авто-тээврийн хэрэгсэл	47,552,000.00	146,252,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-27,991,972.13	-42,552,555.44
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	401,004,356.33	457,679,416.33
39206	Хуримтлагдсан элэгдэл	-96,250,113.34	-122,705,264.42
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	152,464,191.80	153,493,917.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	-41,022,045.46	-49,331,896.44
39214	Бусад үндсэн хөрөнгө	15,015,800.00	15,015,800.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,313,038.47	-4,002,570.47
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	13,660,000.08	13,616,000.10
39301	Програм хангамж	715,000.00	715,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,999.92	-494,999.90
39303	Бусад биет бус хөрөнгө	13,396,000.00	13,396,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>899,856,916.71</b>	<b>1,210,843,411.89</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>13,509,047.39</b>	<b>24,436,797.14</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	13,509,047.39	24,436,797.14
<b>413</b>	<b>Өглөг</b>	13,509,047.39	24,436,797.14
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	01.87

<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	13,509,047.39	24,436,795.27
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	4,400.00
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	13,509,047.39	24,432,395.27
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>886,347,869.32</b>	<b>1,186,406,614.74</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>886,347,869.32</b>	<b>1,186,406,614.74</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	226,654,626.00	226,654,626.00
51101	Өмч: - төрийн	226,654,626.00	226,654,626.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>		
		424,863,252.13	724,921,997.55
51210	Өмнөх үеийн үр дүн	424,863,252.13	424,863,252.13
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	300,058,745.42
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	234,829,991.19	234,829,991.19
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>899,856,916.71</b>	<b>1,210,843,411.88</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,159,655,149.15</b>	<b>1,766,706,893.96</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>64,539,973.11</b>	<b>228,532,268.95</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>64,539,973.11</b>	<b>228,532,268.95</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	46,826,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	46,826,000.00
120007	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Үндсэн хөрөнгө	22,900,000.00	137,404,785.40
120009	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Бараа матермал	41,536,373.11	44,231,483.55
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	103,600.00	70,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,095,115,176.04</b>	<b>1,538,174,625.01</b>
131106	Төсвийн урамшуулал		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>93,472,500.00</b>	<b>83,862,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	93,472,500.00	83,862,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,001,642,676.04</b>	<b>1,454,312,625.01</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,001,642,676.04	1,454,312,625.01
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,257,745,907.62</b>	<b>1,466,648,148.54</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,257,745,907.62</b>	<b>1,466,648,148.54</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,257,745,907.62</b>	<b>1,421,752,048.08</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>739,226,105.00</b>	<b>965,581,100.87</b>
210101	Үндсэн цалин	469,591,873.00	575,128,347.97
210102	Нэмэгдэл	203,054,042.00	322,214,888.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,677,445.00	11,387,667.48
210104	Урамшуулал	58,902,745.00	56,850,196.89
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>92,353,639.66</b>	<b>104,157,900.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	63,929,115.86	70,827,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,689,783.82	8,332,600.00

210203	ҮОМШӨ-ний даатгал	6,054,899.27	4,166,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,334,774.78	4,166,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,345,065.93	16,665,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>92,666,495.39</b>	<b>91,601,610.21</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,793,415.39	6,610,043.41
210302	Түлш, халаалт	83,702,080.00	83,591,566.80
210303	Цэвэр, бохир ус	2,171,000.00	1,400,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>68,797,985.18</b>	<b>50,445,337.03</b>
210401	Бичиг хэрэг	5,469,650.00	11,310,600.00
210402	Тээвэр, шатахуун	24,397,928.00	25,154,520.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,931,600.00	2,935,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	48,000.00	48,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,958,850.72	10,996,417.03
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>117,403,973.49</b>	<b>119,392,724.52</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	101,518,616.09	99,357,466.93
210502	Хоол, хүнс	15,190,357.40	20,035,257.59
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>21,017,000.00</b>	<b>5,385,000.00</b>
210604	Урсгал засвар	20,092,000.00	5,385,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,276,000.00</b>	<b>8,000,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,276,000.00	8,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,538,988.00</b>	<b>1,413,502.06</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,158,000.00	1,107,364.06
210803	Даатгалын үйлчилгээ	80,000.00	183,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	61,100.00	49,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	40,188.00	40,188.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>121,465,720.90</b>	<b>75,774,873.39</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,778,000.00	12,949,392.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	115,687,720.90	62,825,481.39
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>00.00</b>	<b>44,896,100.46</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>44,896,100.46</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	44,826,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>70,100.46</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	70,100.46
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-98,090,758.47</b>	<b>300,058,745.42</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,054,802,226.34</b>	<b>1,372,461,270.19</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>103,600.00</b>	<b>46,896,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>103,600.00</b>	<b>46,896,000.00</b>

120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	00.00	46,826,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	46,826,000.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/		70,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,054,698,626.34</b>	<b>1,325,565,270.19</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	93,472,500.00	83,862,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	93,472,500.00	83,862,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	961,226,126.34	1,241,703,270.19
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	961,226,126.34	1,241,703,270.19
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,086,040,510.66</b>	<b>1,390,832,304.06</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,086,040,510.66</b>	<b>1,390,832,304.06</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,086,040,510.66</b>	<b>1,345,936,203.60</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	739,226,105.00	965,581,099.00
210101	Үндсэн цалин	469,591,873.00	575,128,346.10
210102	Нэмэгдэл	203,054,042.00	322,214,888.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,677,445.00	11,387,667.48
210104	Урамшуулал	58,902,745.00	56,850,196.89
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	92,353,639.66	104,157,900.00
210201	Тэтгэврийн даатгал	63,929,115.86	70,827,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,689,783.82	8,332,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,054,899.27	4,166,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,334,774.78	4,166,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,345,065.93	16,665,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	90,472,500.00	80,861,899.54
210301	Гэрэл, цахилгаан	6,793,415.39	6,610,043.41
210302	Түлш, халаалт	81,508,084.61	72,851,856.13
210303	Цэвэр, бохир ус	2,171,000.00	1,400,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	32,311,900.00	45,076,099.00
210401	Бичиг хэрэг	2,070,000.00	2,307,200.00
210402	Тээвэр, шатахуун	19,566,300.00	28,833,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,931,600.00	2,935,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,744,000.00	5,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,000,000.00	6,000,099.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	83,682,578.00	109,488,312.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	62,215,680.00	88,488,312.00
210502	Хоол, хүнс	15,466,898.00	15,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,000,000.00	6,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	29,151,500.00	36,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,000,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	27,151,500.00	12,000,000.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	1,276,000.00	8,000,000.00
210702	Дотоод албан томилот	1,276,000.00	8,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,024,288.00	2,821,502.06

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,158,000.00	1,107,364.06
210803	Даатгалын үйлчилгээ	80,000.00	183,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	61,100.00	49,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	40,188.00	40,188.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,500,000.00	1,408,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>12,542,000.00</b>	<b>12,949,392.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,542,000.00	12,949,392.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>00.00</b>	<b>44,896,100.46</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>44,826,000.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	44,826,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>70,100.46</b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>-31,238,284.32</b>	<b>-18,371,033.87</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>21,371,100.00</b>	<b>19,000,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>21,371,100.00</b>	<b>19,000,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>21,371,100.00</b>	<b>19,000,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	21,371,100.00	19,000,000.00
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-52,609,384.32</b>	<b>-37,371,033.86</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>92,800,442.17</b>	<b>40,191,057.85</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>40,191,057.85</b>	<b>2,820,023.98</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	226,654,626.00	238,484,708.82	-1,013,903.96	464,125,430.86
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	226,654,626.00	238,484,708.82	-1,013,903.96	464,125,430.86
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-7,959,062.58	-7,959,062.58
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	226,654,626.00	234,829,991.19	424,863,252.13	886,347,869.32
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	226,654,626.00	234,829,991.19	424,863,252.13	886,347,869.32
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	226,654,626.00	234,829,991.19	424,863,252.13	886,347,869.32
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	300,058,745.42	300,058,745.42
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	226,654,626.00	234,829,991.19	724,921,997.55	1,186,406,614.74

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

### Улсын төсвийн гүйцэтгэл

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Өөрчлөлт	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,421,690,100.00	1,325,900,304.06	-95,789,795.94	93.3
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,421,690,100.00	1,325,900,304.06	-95,789,795.94	93.3
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,341,690,100.00	1,281,074,304.06	-60,615,795.94	95.5
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	970,670,800.00	965,581,099.00	-5,089,701.00	99.5
210101	Үндсэн цалин	562,146,100.00	575,128,346.10	12,982,246.10	102.3
210102	Нэмэгдэл	331,435,500.00	322,214,888.53	-9,220,611.47	97.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,000,000.00	11,387,667.48	-612,332.52	94.9
210104	Урамшуулал	65,089,200.00	56,850,196.89	-8,239,003.11	87.3
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	117,263,900.00	104,157,900.00	-13,106,000.00	88.8
210201	Тэтгэврийн даатгал	83,933,400.00	70,827,400.00	-13,106,000.00	84.4
210202	Тэтгэмжийн даатгал	8,332,600.00	8,332,600.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,166,300.00	4,166,300.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	4,166,300.00	4,166,300.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	16,665,300.00	16,665,300.00	0.00	100.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	78,954,800.00	45,076,099.00	-33,878,701.00	57.1
210401	Бичиг хэрэг	2,683,700.00	2,307,200.00	-376,500.00	86.0
210402	Тээвэр, шатахуун	63,985,000.00	28,833,000.00	-35,152,000.00	45.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,016,100.00	2,935,800.00	-80,300.00	97.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,270,000.00	6,000,099.00	1,730,099.00	140.5
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	110,353,700.00	109,488,312.00	-865,388.00	99.2
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	88,540,400.00	88,488,312.00	-52,088.00	99.9
210502	Хоол, хүнс	15,813,300.00	15,000,000.00	-813,300.00	94.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,000,000.00	6,000,000.00	0.00	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	33,000,000.00	33,000,000.00	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,000,000.00	19,000,000.00	0.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	9,000,000.00	9,000,000.00	0.00	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	8,000,000.00	8,000,000.00	0.00	100.0

210702	Дотоод албан томилолт	8,000,000.00	8,000,000.00	0.00	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,048,500.00	2,821,502.06	-2,226,997.94	55.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,121,100.00	1,107,364.06	-2,013,735.94	35.5
210803	Даатгалын үйлчилгээ	190,000.00	183,450.00	-6,550.00	96.6
210804	Тээврийн хэрэгслийн татвар	49,500.00	49,500.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	35,000.00	33,000.00	-2,000.00	94.3
210807	Газрын төлбөр	244,400.00	40,188.00	-204,212.00	16.4
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,408,500.00	1,408,000.00	-500.00	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	18,398,400.00	12,949,392.00	-5,449,008.00	70.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,398,400.00	12,949,392.00	-5,449,008.00	70.4
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	80,000,000.00	44,826,000.00	-35,174,000.00	56.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	80,000,000.00	44,826,000.00	-35,174,000.00	56.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	80,000,000.00	44,826,000.00	-35,174,000.00	56.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,421,690,100.00	1,288,529,270.19	133,160,829.81	90.6
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих			0.00	
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,316,436,200.00	1,241,703,270.19	-74,732,929.81	94.3
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,316,436,200.00	1,241,703,270.19	-74,732,929.81	94.3
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	105,253,900.00	46,826,000.00	-58,427,900.00	44.5

#### Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Өөрчлөлт	Хувь
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	83,861,900.00	83,861,899.54	0.46	100.0
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	83,861,900.00	83,861,899.54	0.46	100.0
Бараа, үйлчилгээний зардал	83,861,900.00	83,861,899.54	0.46	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	80,861,900.00	80,861,899.54	0.46	100.0
Гэрэл цахилгаан	6,258,600.00	6,610,043.41	(351,443.41)	105.6
Түлш, халаалт	72,523,300.00	72,851,856.13	(328,556.13)	100.5
Цэвэр, бохир ус	2,080,000.00	1,400,000.00	680,000.00	67.3
Эд хогшил худалдан авах	3,000,000.00	3,000,000.00	-	100.0

Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	83,861,900.00	83,862,000.00	(100.00)	100.0
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	83,861,900.00	83,862,000.00	(100.00)	100.0
Орон нутгийн төсвөөс	83,861,900.00	83,862,000.00	(100.00)	100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.01	(0.01)	-

## **АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 186,335.9 мянган төгрөгийн 10 алдаа, зөрчлийг илрүүлснээс 181,404.3 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 5 зөрчилд зөвлөмж 2 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

### **Залруулсан алдаа**

Эрүүл мэндийн газраас ирүүлсэн эм, хэрэгсэл, аж ахуйн материалыг хандив, шилжүүлэн авснаар бүртгэсэн, улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хуваарилсан тээврийн хэрэгсэл тоног төхөөрөмжийг шилжүүлэн авснаар, төвлөрүүлэх шилжүүлгийг орлогын дансанд тус тус бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 заалт "үнэн зөв байх;" заалттай нийцэхгүй "Үнэлгээ ба хуваарилал" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул эрүүл мэндийн даатгалаас санхүүжих санхүүжилтийн дүнгээр бүртгүүлж залруулга хийсэн. Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 4.931,6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 20,123.9 мянган төгрөгөөс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

### **Албан шаардлага**

1. Эм, эмнэлгийн хэрэгслийн шууд худалдан авалтын дүн шууд худалдан авах дээд хязгаараас 16,114.8 мянган төгрөгөөр давсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно." заалттай болон "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа

2. Засгийн Газрын 2023 оны 241 тоот тушаалын 6-р хавсралтаар батлагдсан "Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээ"- ээс хэтрүүлэн олгосон 489.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

### **Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Тус эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжсэнтэй холбоотой болон бусад шинээр гарсан дүрэм, журамтай нийцэхгүй болсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт

*бичгийг баталж, мөрдөж ажиллана.*” заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан дүрэм, журамтай нийцүүлэн шинэчлэн боловсруулж, мөрдөх.

## **2. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт

5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 37 гүйлгээнээс 30 гүйлгээ хугацаа хоцорч 6 гүйлгээг мэдээлээгүй, зарлагын 18 гүйлгээнээс 2 гүйлгээ хугацаа хоцорч, 11 гүйлгээ мэдээлээгүй байгаа нь “Шилэн дансны тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;*” заалт, 6 дугаар зүйлийн 6.4.5 “*цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;*” 6.4.8 “*бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;*” заалт болон “*нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах.

## **3. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийн асуудал**

Илрүүлэлт:

2024 онд сумын иргэдэд үзүүлсэн тусламж, үйлчилгээний санхүүжилт 1,076,721.2 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас нэхэмжилснээс 18,497.0 мянган төгрөг хасагдсан нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6 “*эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх*”, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны “*Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай*” 05 дугаар тогтоолын 3.1 “*Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж...*” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй “*нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны цахим системийн дотоод хяналтыг сайжруулж, хасагдалтын хэмжээг өмнөх оноос бууруулах.

## **4. Ахмадын сангийн талаар**

Илрүүлэлт:

Цагаан Уул сумын эрүүл мэндийн төв нь ахмадын сан байгуулаагүй байгаа нь Ахмадын настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 “*Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах...*” гэж заасантай нийцэхгүй, “*нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллагын цалингийн сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөөр Ахмадын сан байгуулах хөрөнгийг төсөвт тусган хэрэгжүүлэх.

## 5. Эмийн үлдэгдлийн талаар

### Илрүүлэлт

Бараа материалын үлдэгдэлд бүтэн жилийн турш зарлагын хөдөлгөөн хийгдээгүй, өмнөх оноос шилжиж ирсэн 4,442.6 мянган төгрөгийн эмийн үлдэгдэл байгаа нь бараа материалын үлдэгдлийг эхэлж авснаа эхэлж зарлагдах аргыг тууштай мөрдөөгүй, тухайн эмийг зарцуулах өвчлөлийн тохиолдол гараагүй зэргээс шалтгаалсан байна.

### Өгсөн зөвлөмж

Эмийн үлдэгдэл, хэрэгцээ шаардлагыг бодитоор тооцон эмийн захиалгыг өгч, материалын үлдэгдлийг эхэлж авснаа, эхэлж зарлагдах, эмийн хадгалалтын хугацаанд байнга хяналт хийж, холбогдох арга хэмжээг тухай бүр авч байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх, төлбөрийн актыг барагдуулах ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд 2025 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор оруулж, баталгаажуулна уу.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эрүүл мэндийн газраас ирүүлсэн эм, хэрэгсэл, аж ахуйн материалыг хандив, шилжүүлэн авснаар бүртгэсэн	1	43,929.5			1	43,929.5	1	43,929.5		
улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хувиарлагдан ирсэн тээврийн хэрэгсэл тоног төхөөрөмжийг шилжүүлэн авснаар бүртгэсэн	1	137,404.8			1	137,404.8	1	137,404.8		
Төвлөрүүлэх шилжүүлгийг орлогын дансанд бүртгэсэн	1	70,100.45			1	70,100.45	1	70,100.45		
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>181.404.4</b>				<b>181.404.4</b>		<b>181.404.4</b>		

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан дүрэм, журамд нийцүүлэн шинэчлээгүй.	1	-					1	-
Эрүүл мэндийн төвийн дарга Н.Бат-Эрдэнийн албан тушаалын жишиг цалингийн хэмжээг нэмэгдүүлэн олгосон	1	489,0			1	489,0		
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>489,0</b>			<b>1</b>	<b>489,0</b>	<b>1</b>	

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 37 гүйлгээнээс 30 гүйлгээ хугацаа хоцорч 6 гүйлгээг мэдээлээгүй, зарлагын 18 гүйлгээнээс 2 гүйлгээ хугацаа хоцорч, 11 гүйлгээ мэдээлээгүй	1	-				-	1	
Эмнэлгийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийг цахим системд бүрэн, үнэ зөв оруулаагүй, дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлснээс нэхэмжилсэн санхүүжилтийг бүрэн авч чадаагүй.	1						1	
Эм, эмнэлгийн хэрэгслэлийн шууд худалдан авалтын дүн шууд худалдан авах дээд хязгаараас давсан.	1				1			
Ахмадын санг байгууллагын төсөвт тусгаж, батлуулаагүй байна.	1						1	-
Бараа материалын үлдэгдэлд өмнөх оны үлдэгдлээс зарцуулаагүй эм, тан, тариа, вакцины үлдэгдэлтэй	1	4,442.6					1	4,442.6
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>4,442.6</b>			<b>1</b>		<b>4</b>	<b>4,442.6</b>

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

№ 36/А2240469/

Мөрөн сум

ХӨА - 2025/091/МА - ЦА ТИЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Цагаан-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эмийн шууд худалдан авалтын дүн нь "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор тогтоосон шууд худалдан авч болох барааны төсөвт өртгийн дээд хязгаараас 16,114,800 (арван зургаан сая нэг зуун арван дөрвөн мянга найман зуу) төгрөгөөр хэтэрсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно." заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа Засгийн газраас тогтоосон шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг баримтлан ажиллаж, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор гаргаж, төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд оруулж, баталгаажуулах;

2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Бат-Эрдэнэ, нягтлан бодогч Х.Дуламсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

АУДИТОР

Г.ИЧИНХОРЛОО

6724030535



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

№ 35/А2270469/

Мөрөн сум

ХАА - 2025/091/НА - ЦА - ТУ19

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Цагаан -Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд Цагаан-Уул сумын Засаг даргын 2024 оны Б/01 тоот захирамжаар Сумын эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Бат-Эрдэнийн үндсэн цалинг Засгийн газрын Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар тогтоосон "Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээ"-г нэмэгдүүлэн тогтоосноос нийт 489,000 (дөрвөн зуун наян есөн мянган) төгрөгийн цалин илүү олгосон байна.

Дээрх зөрчил нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.14-т "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээ, сүлжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.", Эрүүл мэндийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-т "Эрүүл мэндийн ажилтны цалингийн тусгай сүлжээний доод жишгийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, онцлогийг харгалзан хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв гэж заасантай тус тус нийцэхгүй," үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3. "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ НЬ** :

1. Албан хаагчдын цалинг тогтоохдоо хүчин төгөлдөр мөрдөж буй цалингийн сүлжээг мөрдөж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоох, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 20-ны дотор гаргаж, төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд оруулж, баталгаажуулах;

2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цагаан-Уул сумын Засаг дарга С.Гончигням, Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Бат-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

Г.ИЧИНХОРЛОО

6724030544